



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ГАЗАР

**БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ
ШАЛГАЛТ**

*Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын
Гаалийн улсын ахлах байцаагч Ц.Лхагвасүрэн*

2018.12.14
УЛААНБААТАР ХОТ

ГААЛИЙН ХЯНАЛТЫН ҮЕ ШАТ

**БҮРДҮҮЛЭЛТИЙН
ӨМНӨХ ҮЕ ШАТ**

**БҮРДҮҮЛЭЛТИЙН
ҮЕ ШАТ**

**БҮРДҮҮЛЭЛТИЙН
ДАРААХ ҮЕ ШАТ**

**ЭНЭ ҮЕ ШАТАНД
ХЭРЭГЖДЭГ
ГААЛИЙН ХЯНАЛТЫН
НЭГ ХЭЛБЭР БОЛ
БҮРДҮҮЛЭЛТИЙН
ДАРААХ ШАЛГАЛТ
ЮМ.**

Эх сурвалж:

1. “Гаалийн горимыг хялбарчлах уялдуулах конвенц” (ДГБ, 1999);
2. “Гаалийн хяналтын стратеги” (ГЕГ, 2011 он)

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Олон улсын хэмжээнд:

1. ДГБ-ын Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай шинэчлэн найруулсан киото конвенц: 6 дугаар бүлэг

***2. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр:
Зүйл 7.5.1 - 7.5.4***

Үндэсний хэмжээнд:

- 1. Монгол Улсын Гаалийн тухай хууль***
- 2. Бусад холбогдох хууль тогтоомж***

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн хяналтаас гаргах зөвшөөрөл олгосны дараа гадаад худалдаанд оролцогчдын худалдааны мэдээлэл, санхүү, нягтлан бодох бүртгэлийн болон анхан шатны бичиг баримт, цахим сангийн мэдээллийг нягтлан шалгах замаар гаалийн мэдүүлгийн үнэн зөвийг тодорхойлох, хууль сахилтын түвшинг үнэлэх шалгалт юм.



гаалийн хяналтад орох

чөлөөт эргэлтэд орох



барааг эзэнд олгох зөвшөөрөл



БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Олон Улсын Гэрээ, Конвенц болон Үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

Гадаад худалдаанд оролцогчдын хууль сахилтын түвшинд үнэлэлт дүгнэлт өгөх

Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх

Худалдааны луйвартай тэмцэх, төсвийн орлогыг үнэн зөв бүрдүүлэх

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ

Гаалийн байгууллагын хувьд:



- ААН, байгууллагын бизнесийн үйл ажиллагааны талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй болно; Ингэснээр тухайн ААН, байгууллагатай илүү нягт хамтран ажиллах боломж бүрдэнэ;
- Гаалийн болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх нөхцөл боломж бий болно;
- Төсвийн орлогыг хамгаалах, бүрэн бүрдүүлэх, худалдааны луйварыг илрүүлэх, таслан зогсоох нөхцөл боломжийг бий болно;
- Гадаад худалдааг зохицуулах лиценз, квот, демпинг гэх мэт чиглэлүүдэд хяналтыг илүү өргөн хүрээтэй тавих.

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ

ААН, байгууллагын хувьд:


- Хууль ёсны худалдаа эрхлэгчийн гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа хөнгөвчлөгдөнө; Ингэснээр гаалийн бүрдүүлэлтэд зарцуулагдах цаг хугацаа, зардал буурна;
- Гаалийн болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байгаа эсэхэд болон өөрийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, улмаар хууль сахилтын түвшингөө дээшлүүлэх нөхцөл боломж бүрдэнэ;
- Хууль сахилтын түвшингөө дээшлүүлж, илүү сайн хууль сахигч болсноор гаалийн байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөр тухайлбал, ЭЗИО-ын хөтөлбөрт хамрагдах боломж бүрдэнэ;
- Гаалийн байгууллагаас баримталж буй бодлого, мөн гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаарх илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй болно.

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ЦАР ХҮРЭЭ (Сүүлийн 2 жилээр)



Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх чиглэлд энэ шалгалтын хэрэгцээ, шаардлага Үндэсний хэмжээнд төдийгүй Олон Улсын хэмжээнд жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Нөхөн бүрдүүлэлтийн цар хүрээ (сүүлийн 2 жилээр)



Гаалийн бүрдүүлэлтийн үе шатанд хийгдэж буй хянгалт, шалгалт нь зөвхөн мэдүүлэгчийн гаргаж өгсөн тухайн ачилттай холбоотой бичиг баримт, мэдээлэлд үндэслэгддэг бол **бүрдүүлэлтийн дараах шалгалт нь хууль ёсны худалдааг хөнгөвчлөхийн зэрэгцээ тухайн ААН, байгууллагын гадаад худалдааны үйл ажиллагаанд бүхэлд нь үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг олгодоогоороо онцлог юм.**

Нийт нөхөн бүрдүүлэлтийн 90 хувь нь онлайнаар худалдан авалтаар хийгдсэн програм хангамж, зураг төсөл, лиценз зэрэг бараа байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Гаалийн ерөнхий газрын дэргэдэх
Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар
Утас: 350067, 242617
Цахим хаяг: bdsh@ecustoms.gov.mn